



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 8 дугаар сарын 6

Дугаар 3

Улаанбаатар хот

III ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдаан 2023 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 11.00 цагт Төрийн ордон дахь "Чингис хаан танхим"-д ⁷⁰³ хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт болсон үерийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

*Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар*

2. Цаг агаарын төлөв байдлын талаар

*Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Оюунжаргал*

3. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар, Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаяр, Барилга хот, байгуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Даваасүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Бямбацогт, Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн нарт:

1.1. Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт 2023 оны 8 дугаар сарын 5-ны өдөр болсон үерийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд шаардлагатай хүн хүч, машин, техникийг дайчлан гаргаж, Нийслэлийн онцгой комисст дэмжлэг үзүүлж, шуурхай зохицуулалтаар хангаж ажиллах,

Хоёр. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Чинзоригт:

2.1. Үерт өртсөн айл өрх, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг газар дээр нь үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах,

2.2. Үерийн улмаас халдварт өвчин тархах эрсдэл нэмэгдэж байгаа тул эрүүл мэндийн байгууллагуудын бэлтгэл, бэлэн байдлыг хангах, болзошгүй халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг тогтмол түгээх, үерийн голомтод болон шаардлагатай газруудад ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран шуурхай зохион байгуулах,

Гурав. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал Ж.Болдод:

3.1. Нийгмийн хэв журам зөрчигдөх, иргэдийн эд хөрөнгийг хулгайлах, тонох гэх мэт гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллах, шаардлагатай хүн хүчийг нэмэгдүүлэх,

Дөрөв. Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэнд:

4.1. Улаанбаатар хот орчимд үүссэн үерийн улмаас дахин хүний амь, нас эрүүл мэнд, эд хөрөнгөд аливаа хохирол учрах, цахилгаан эрчим хүч тасалдах, осол гарах нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэх зохион байгуулалт, хяналтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

4.2. Мэргэжлийн байгууллагын үзлэг шалгалтад үндэслэн аюулгүй байдлыг хангаж хязгаарлалтад орсон айл өрх, аж ахуйн нэгжийн цахилгаан эрчим хүчийг сэргээх ажлыг шуурхай зохион байгуулах,

Тав. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад:

5.1. Үерт өртсөн айл өрхүүдийн судалгааг нэн даруй гаргаж, иргэдийг нэн шаардлагатай цэвэр ус, хоол хүнс, дулаан хувцас, гэр, түр байраар хангах ажлыг шуурхай зохион байгуулж, нийслэл, дүүргийн онцгой комисст дэмжлэг үзүүлэх, нэгдсэн зохицуулалт, удирдлагаар хангаж ажиллах,

**Зургаа. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазарт:**

6.1. Засгийн газрын 2019 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журмын дагуу үерийн хохирлын анхан шатны үнэлгээ хийж, Улсын онцгой комисс, Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх,

6.2. Хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийн тооцоог яаралтай гаргаж Улсын онцгой комисс, Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх,

Долоо. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Ганзул, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Оюунжаргал, МҮОНРТ-ийн ерөнхий захирал, Улсын онцгой комиссын гишүүн А.Бүрэнбаатар нарт:

7.1. Цаг агаарын сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийг илүү нарийвчлан гаргаж тогтмол давтамжтайгаар иргэдэд хүртээмжтэй байдлаар түгээх,

Найм. Бүх шатны Онцгой комисст:

8.1. Цаг уурын байгууллагын мэдээллээр нийт нутгаар усархаг бороо үргэлжлэн орж, голуудын усны түвшин огцом нэмэгдэж, үерийн аюултай түвшинг даван үерлэж байгаа тул болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх, иргэд, аж ахуйн нэгжүүдэд сэрэмжлүүлэг хүргэх, гүүр, гарамгүй газраар гол, мөрөн гатлахгүй байх, анхаарал болгоомжтой зорчих талаар анхааруулах,

8.2. Гол, мөрөн, нуурын дагуу хөдөлгөөнт эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрэг орчмоор үйл ажиллагаа явуулдаг амралт, сувилал, аж ахуйн нэгжүүдэд болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөмж өгөх, амрагчдын аюулгүй байдлыг хангаж байгаа байдалд хяналт шалгалтын ажил зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах,

8.3. Мэргэжлийн байгууллага, нутгийн захиргааны байгууллага хамтран үерийн хамгаалалтын далан, суваг, шуудуу, ус зайлуулах зориулалттай инженерийн байгууламжид үзлэг, шалгалт зохион байгуулан, цэвэрлэгээ хийх, өргөтгөх, хүчитгэх, хүчитгэхэд шаардлагатай элс, хайргыг бэлтгэх, зөөвөрлөх машин, ажиллах хүч хэрэгслийг урьдчилан томилгоожуулах,

8.4. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний үерийн үед ажиллах төлөвлөгөө, хүн хүч хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөөг тодотгох, холбогдох байгууллагуудын хүн хүч, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах,

8.5. Үерийн үед ажиллах мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоо, харилцан ажиллагааг хангаж, шуурхай мэдээ, мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх,

8.6. Үерийн дараах лаг шавар, хогийг зайлуулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх зэрэг ажлуудыг шуурхай хэрэгжүүлэх,

8.7. Гол, мөрөн, нуурын арал, тохой, эрэг дагууд болон уулын ам, бэл, гуу жалга, судгийн аманд айл өрх суурьшихгүй байхыг анхааруулах, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахыг хориглох, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх, шаардлага хүргүүлэх,

8.8. Амралт, зугаалгын улирал үргэлжилж байгаа тул иргэдэд бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ голын усанд орохгүй байх, зориулалтын бус, стандартын шаардлага хангахгүй хөвөгч хэрэгсэл, завь зэргийг хэрэглэхгүй байх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээллийг бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, авто зам, тээврийн хяналтын цэг, хөдөлгөөнт эргүүлээр дамжуулан тогтмол хүргэх,

8.9. Болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, Улсын онцгой комиссын 2023 оны “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллах,

8.10. Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн албан даалгаврын хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллах,

8.11. 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах,

8.12. Цаг уурын байгууллагаас гаргаж буй бэлчээрийн даац, зудын эрсдэлийн мэдээ, цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдлийн талаарх зарлан мэдээллийг ард иргэдэд шуурхай хүргэх, болзошгүй байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх,

8.13. Аймаг, сумын аюулгүйн нөөцөд өвс, тэжээл бэлтгэх ажлыг цаг алдалгүй зохион байгуулах, зуншлага тааруу байгаа, хадлан бэлтгэх боломжгүй аймаг, сумд бусад аймаг, орон нутгаас өвс тэжээл бэлтгэх, худалдан авах талаар хамтран ажиллах,

8.14. 2023-2024 оны өвөл, хавар отор, нүүдэл хийх малчдын судалгаа, оторлох малын тоо, толгойг аймаг, орон нутгаар нэгтгэж гаргах, зохион байгуулалтыг сайтар хийж бусад аймаг орон нутгийн удирдлагуудтай гэрээ хийх,

8.15. Иргэд, аж ахуйн нэгжүүдэд мал, эд хөрөнгөө даатгалд хамруулах талаар зөвлөмж, мэдээлэл өгч, орон нутгийн хэмжээнд зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

8.16. Мал сүргийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ, малын дархлаажуулалт, угаалга, туулгалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийг эрчимтэй явуулах, ялангуяа бусад аймгийн нутагт отроор өвөлжиж, хаваржих малыг бүрэн хамруулах,

8.17. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд “Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана”, “Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна” гэж заасныг мөрдлөг болгон 2024 оны төсөвт гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны зардлыг бодитоор тооцож тусгах,

Ес. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:

9.1. Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын үйл ажиллагааг идэвхижүүлж, удирдлагаар хангаж ажиллах.

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

